

**НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН АНКЕТ**

Д/ д	Шалгуур үзүүлэлт	Мэдээлэл
1	<b>Нэр</b> Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, нэрээ өөрчилж байсан бол өмнө нь хэрэглэж байсан нэр	Өндөрийнхөн овогт Тогоохүүгийн Ихтамир
2	<b>Хүсэлт гаргагчийн хаяг</b> Иргэний үнэмлэхэд байгаа хаяг	
3	<b>Төрсөн огноо</b> Төрсөн газар	
4	<b>Боловсрол</b> Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн жагсаан бичнэ. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.	<ul style="list-style-type: none"> <li>➤ Дотоод хэргийн их сургууль, Хууль зүйн ухааны магистр (2018-2019)</li> <li>➤ Орхон их сургууль, Дээд, эрх зүйч, бакалавр (1997-2001)</li> </ul>
5	<b>Ажил эрхлэлт</b> Их, дээд сургууль төгссөнөөс хойш ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон бусад байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсаан бичнэ. Ажил олгогчийн нэр, хаяг, утас, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.	<ul style="list-style-type: none"> <li>➤ Байгууллагын нэр: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс Байгууллагын хаяг: Чингэлтэй дүүрэг, Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын 11 дүгээр байр, 5 давхар Ажлын байрны нэр: Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга</li> <li>➤ Байгууллагын нэр: Монголын Өмгөөлөгчдийн Холбоо Ажлын байрны нэр: Нийслэлийн Өмгөөлөгчдийн зөвлөл</li> <li>➤ Байгууллагын нэр: “Монтуса” ХХК Байгууллагын хаяг: Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, Канон төв, 5 давхар Ажлын байрны нэр: Хуулийн зөвлөх</li> </ul>
6	<b>Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал</b> Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн эсхүл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний алинд нэр дэвшиж байгаа талаар бичнэ.	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэрээ дэвшүүлж байгаа.

7	<p><b>Эрх зүйч мэргэжлээр эрхэлсэн ажил</b> Хүсэлт гаргагч эрх зүйч мэргэжлээр сүүлийн арваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;</li> <li>-ажлын байрны тодорхойлолт;</li> <li>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;</li> <li>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.</li> </ul>	<ol style="list-style-type: none"> <li>1. <b>Албан тушаалын нэр:</b> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалтын Хэлтсийн даргаар ажилладаг. Тус байгууллагад нийт 9 жил 4 сар ажиллаж байна. Үүнээс: <ul style="list-style-type: none"> <li>- Гомдол, хяналт шалгалтын Хэлтсийн даргаар 2015-10-30-наас одоог хүртэл 4,7 жил</li> <li>- Гомдол, хяналт шалгалт хариуцсан Ахлах мэргэжилтэн, Референт, Ахлах референтээр 2011-11-07-ны өдрөөс 2015-10-30-ныг хүртэл нийт 3 жил 11 сар</li> <li>- Хэвлэл мэдээлэл хариуцсан Референт, Гомдол хариуцсан Референтээр 2008.01.06-наас 2008.06.06-ны өдрийг хүртэл 10 сар</li> </ul> </li> </ol> <p><b>байгууллагын хаяг:</b> Чингэлтэй дүүрэг, Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын 11 дүгээр байр, 5 давхар, утас: 51-262786, 51-262971, вэб сайт: <a href="https://www.nhrcom.gov.mn/">https://www.nhrcom.gov.mn/</a></p> <p><b>албан тушаалын тодорхойлолт:</b> Комиссын гишүүд хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, гомдол мэдээлэл хүлээн авах, шалгах, шийдвэрлэх, Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, Комиссын гишүүний бүрэн эрхийг түүний нэрийн өмнөөс төлөөлөн хэрэгжүүлэх болон хуульд заасан бусад бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.</p> <ol style="list-style-type: none"> <li>2. <b>Албан тушаалын нэр:</b> Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 71 дүгээр тушаалаар олгосон өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн гишүүн, өмгөөлөгчөөр 2003-2011 оныг хүртэл нийт 8 жил ажилласан.</li> </ol> <p><b>байгууллагын хаяг:</b> Баянгол дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө-46, Гранд плаза 15-р давхар 1505, 1506 тоот, утас:70127491, 70126861 / факс: (976), вэб сайт: <a href="https://www.ama.org.mn/">https://www.ama.org.mn/</a></p> <p><b>албан тушаалын тодорхойлолт:</b> Хууль зүйн асуудлаар амаар болон бичгээр зөвлөгөө өгөх, зөвлөмж, дүгнэлт гаргах, хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх зохиох, төрийн болон бусад байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх, түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүхэд төлөөлөх.</p> <p>Миний бие Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст 9 жил 4 сар, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн, өмгөөлөгчөөр 8 жил нийт 17 жил 4 сар хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр ажилласан байна.</p>
8	<p><b>Ёс зүй</b> Доор дурсан асуудлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, түүний гол агуулгыг тодорхойлно.</p> <ul style="list-style-type: none"> <li>-сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан эсэх;</li> <li>-сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан эсэх.</li> </ul>	Үгүй

<p>9</p>	<p><b>Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар</b>  Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.  -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;  -үйл ажиллагааны гол агуулга;  -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;  -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;  -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл;  -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. <b><u>үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:</u></b> Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020-04-15-ны өдрийн А/66 дугаар тушаалаар байгуулагдсан 2020-01-10-ны өдөр батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллаж байна.  <b><u>үйл ажиллагааны гол агуулга:</u></b> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар санал боловсруулах.  <b><u>үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:</u></b> Хуулийн хэрэгжилтийг хангуулах саналыг боловсруулсан байна.  <b><u>хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар:</u></b> Ажлын хэсгийн тушаалын хуулбарыг хавсаргав.</li> <li>2. <b><u>үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:</u></b> Монгол Улсын Их Хурлаас байгуулсан Түр хорооноос 2019-12-10-ны өдөр зохион байгуулсан “Эрүү шүүлтээс ангид байх эрхийн асуудал” хэлэлцүүлэгт оролцож, “Эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангахад тулгамдаж буй зарим асуудал” сэдвээр илтгэл тавьсан.  <b><u>үйл ажиллагааны гол агуулга:</u></b> Эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам.  <b><u>үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:</u></b> Монгол Улс дахь эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлыг тохиолдол, тоо баримт, судалгаанд тулгуурлан гаргаж тавьсан.  <b><u>хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</u></b> “Эрүү шүүлтээс ангид байх эрхийн асуудал” хэлэлцүүлгийн DVD-г хавсаргав.</li> <li>3. <b><u>үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:</u></b> Дотоод хэргийн их сургуулийн Ахисан шатны боловсролын сургуульд суралцаж Магистрын зэрэг хамгаалсан. Тус сургуулийн захирлын 2019-06-28-ны өдрийн Б/153 дугаар тушаалаар Е20191695 дугаар магистрын диплом олгосон.  <b><u>үйл ажиллагааны гол агуулга:</u></b> Магистрын зэрэг хамгаалсан сэдэв: “Ажлын байран дахь бэлгийн дарамт, түүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь” Товч агуулгын хувьд жендэрээс үүдэлтэй хүний эрхийн ноцтой зөрчлийн нэг хэлбэр болох ажлын байран дахь бэлгийн дарамт, түүний хор уршиг, Монгол Улс дахь өнөөгийн нөхцөл байдал, олон улсын болон дотоодын эрх зүйн зохицуулалт, түүнийг боловсронгуй болгох.  <b><u>үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:</u></b> Дотоодын эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, ажлын байран дахь бэлгийн дарамтыг Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиар зохицуулах зайлшгүй шаардлагатай талаарх саналыг тохиолдол, судалгаа, дүн шинжилгээний үндсэн дээр дэвшүүлсэн.  <b><u>хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</u></b> Магистрын дипломын хуулбарыг хавсаргасан болно.</li> </ol>
----------	---	--

	<p>4. <b><u>үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:</u></b> Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019-06-12-ны А/104 дүгээр тушаалаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасныг үндэслэн “Эрүү шүүлтээс ангид байх эрх” зөрчигдсөн тухай гомдол, мэдээллийг судлан, санал танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллав.</p> <p><b><u>үйл ажиллагааны гол агуулга:</u></b> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлд тусгагдснаар “хуулийн байгууллагын албан хаагчид нь эрүү шүүлт тулгасан” гэх асуудлыг нягтлах, шалгах, үр дүнг Хууль зүй, дотоод хэргийн сайдад танилцуулах зорилготой.</p> <p><b><u>үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:</u></b> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст иргэдээс 2018, 2019 оны эхний улирлын байдлаар ирүүлсэн эрүү шүүлтээс ангид байх эрх зөрчигдсөн гэх гомдлыг нягтлан шалгах талаар Комисс, шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төлөөлөл ажлын хэсэгт орж ажилласан бөгөөд өөр өөрсдийн байгууллагын чиглэлээр шалгаж, мэдээллээ солилцож, дүнг нэгтгэн ажилласан байна.</p> <p><b><u>хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар:</u></b> Ажлын хэсэг байгуулсан тушаал болон тухайн ажлын хэсгийн хурлын хөтөлбөрийн хуулбарыг тус тус хавсаргасан болно.</p> <p>5. <b><u>үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:</u></b> Монголын Хуульчдын Холбооноос 2019-06-13-ны өдөр “Эрх зүйн шинэчлэлд хуульчдын үүрэг, оролцоо” уриан дор зохион байгуулсан “Хуульчдын форум-2019”-ын “Эрүүдэн шүүх, хүнлэг бус, хэлбэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх нь” сэдэвт салбар хуралдаанд хэлэлцүүлэгчээр оролцсон.</p> <p><b><u>үйл ажиллагааны гол агуулга:</u></b> Эрүүдэн шүүх, бусад хүнлэг бус хэлбэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог боловсронгуй болгох санал, зөвлөмжийг хуульчид, хүний эрхийн байгууллага, иргэний нийгмийн болон олон талын төлөөллийг оролцуулан тал бүрээс нь авч хэлэлцэх тодорхойлох.</p> <p><b><u>үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:</u></b> Хуульчийн нэр хүнд, хариуцлага, нийгмэд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа бөгөөд уг салбар хуралдаанаас гарсан санал, зөвлөмжийг Монгол Улсын Засгийн газарт хүргүүлсэн.</p> <p><b><u>хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар:</u></b> Мэдээллийг <a href="https://www.trends.mn/n/8994">https://www.trends.mn/n/8994</a> харах боломжтой бөгөөд тус Форумд оролцож, хуульчийн нэр хүнд, хариуцлага, нийгмэд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулсныг маань үнэлж Талархал гардуулсныг энэхүү анкетад хавсаргасан болно.</p> <p>6. <b><u>үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:</u></b> Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2017-01-10-ны өдрийн 04 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газраас 2016-12-26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллав.</p> <p><b><u>үйл ажиллагааны гол агуулга:</u></b> Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай.</p>
--	---

**үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:** Эрүүгийн хууль, Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг 2017-05-11-ний өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэж баталсан бөгөөд 2017-07-01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

**хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар:**

<https://www.legalinfo.mn/law/details/11634> нийтлэгдсэн, Ажлын хэсэг байгуулсан Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2017-01-10-ны өдрийн 04 дугаар тогтоолоор тогтоолын хуулбарыг хавсаргав.

7. **үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017-12-13-ны өдрийн А/299 дугаар тушаалаар Эрүүгийн хуульд цаазаар авах ялыг тусгах асуудлыг судалж, санал дүгнэлт боловсруулах Ажлын хэсэгт ажилласан.

**үйл ажиллагааны гол агуулга:** Монгол Улсын Ерөнхийлөгчөөс бага насны хүүхдийг хүчирхийлсэн, амийг нь хөнөөсөн, тарчлаан зовоосон, балмад хэрцгий аллагын гэмт этгээдүүдэд цаазаар авах ялыг сэргээн хэрэглэх тухай саналаа Хууль зүй, дотоод хэргийн сайдад 2017-11-27-ны өдрийн Е/15 дугаар албан бичгээр “хүчирхийллийн гэмт хэрэг, ялангуяа бага насны хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэж, тэднийг бэлгийн дур хүслээ хангах хэрэгсэл болгож байгаа нь нийгмийн өмнө тулгамдаж буй асуудал болоод байгаа талаар дурдаад Эрүүгийн хуульд цаазаар авах ялыг тусгах талаар арга хэмжээ авч, холбогдох хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх асуудлыг зохион байгуулж ажиллахыг хүсэж, Эрүүгийн хуульд цаазаар авах ялыг тусгах талаар өөрчлөлт оруулж, Иргэний болон улсын төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт 2 дугаар протоколоос гарах ажлыг хуулийн дагуу Засгийн газар эхлүүлэх нь зүйтэй” талаар ирүүлсэн албан бичгийн дагуу холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудын төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулагдсан.

**үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:** НҮБ-ын ИБУТЭТОУП-ын Хоёрдугаар нэмэлт протоколд Монгол Улс нь Монгол Улс 2012-03-13-ны өдөр нэгдэн орж, соёрхон баталсан бөгөөд тухайн Нэмэлт протоколоос гарах талаар олон улсын эрх зүйн зохицуулалт байхгүй учир цаазаар авах ялыг Эрүүгийн хуульдаа тусгах үндэслэлгүй юм. Тус яамнаас энэ талаар Ажлын хэсгийн гаргасан дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгч болон Засгийн газарт хүргүүлсэн байна.

**хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.** Ажлын хэсгийн тушаалыг хавсаргав.

8. **үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2017-04-27-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газраас 2017-04-18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллав.

**үйл ажиллагааны гол агуулга:** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчилэн найруулах.

		<p><b><u>үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:</u></b> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2017-06-19-ний өдөр хэлэлцэн баталсан бөгөөд 2017-07-01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн.</p> <p><b><u>хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар:</u></b>  <a href="https://www.legalinfo.mn/law/details/12701">https://www.legalinfo.mn/law/details/12701</a> нийтлэгдсэн, Ажлын хэсэг байгуулсан Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2017-04-27-ны өдрийн 11 дүгээр тогтоолын хуулбарыг хавсаргав.</p> <p><b>9. <u>үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:</u></b> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Ажлын албаны даргын тушаалаар хууль тогтоомж, эрх зүйн актад санал өгөх Ажлын хэсэгт ажиллаж байна.</p> <p><b><u>үйл ажиллагааны гол агуулга:</u></b> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөл хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцэж буй эсэхэд санал боловсруулах</p> <p><b><u>үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:</u></b> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос сүүлийн 3 жилийн байдлаар тус Ажлын хэсгийн саналыг үндэслэн нийт 97 хууль тогтоомж, эрх зүйн актын төсөлд хууль санаачлагчид санал хүргүүлсэн байна.</p> <p><b><u>хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар:</u></b> Ажлын хэсгийн тушаалын хуулбарыг хавсаргав.</p> <p><b>10. <u>үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:</u></b> Монголын Хуульчдын Холбооноос 2014-07-07-ны өдөр №1546 дугаар бүхий Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ олгосон.</p> <p><b><u>үйл ажиллагааны гол агуулга:</u></b> Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, шүүн таслах ажиллагаанд оролцох, бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэх.</p> <p><b><u>үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:</u></b> Хууль зүйн асуудлаар амаар болон бичгээр лавлагаа, зөвлөгөө өгөх, хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх боловсруулах, хянах, батла, иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр хууль тогтоомжид заасан хууль зүйн туслалцаа үзүүлэх, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зохих байгууллагад төлөөлөх, нэхэмжлэл, хүсэлтийг шийдвэрлэх, хохирол барагдуулахад чиглэсэн аливаа зөвшилцөх, эвлэрүүлэх үйл ажиллагаа явуулах, шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцох зэргээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах.</p> <p><b><u>хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар:</u></b> Хуульчийн гэрчилгээний хуулбарыг хавсаргав.</p>
10	<p><b>Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр эрхэлсэн ажил</b>  Хүсэлт гаргагч хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр сүүлийн таваас доошгүй жил эрхэлсэн ажлыг</p>	<p><b><u>Хүний эрхийг хөхиүлэн дэмжих чиглэлээр:</u></b></p> <p><b><u>үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:</u></b> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн хэлтсийн даргаар ажиллаж байна. Тус байгууллагад ажилласан хугацаа 9 жил 4 сар.</p>

<p>хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;</li> <li>-ажлын байрны тодорхойлолт;</li> <li>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;</li> <li>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.</li> </ul>	<p><b>Ажлын байрны тодорхойлолт:</b> Эрхэлж буй ажлын албан тушаалын тодорхойлолтод хүний эрхийг хөхиүлэн дэмжих чиг үүрэг шууд хамаардаггүй боловч энэ чиглэлээр тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсээр ирсэн юм. Тухайлбал, “Хүний эрхийн үндсэн ойлголт”, “Хүний эрхэд суурилсан хандлага”, “Албадан хөдөлмөрийн асуудал”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь”, “Жендерт суурилсан хүчирхийлэл ба ажлын байрны бэлгийн дарамт”, “Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь”, “Эрүү шүүлт ба хүний эрх”, “Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн эрхийн асуудал”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн хэрэгжилт”, “Жендэр ба хүний эрх”, “Жендэрийн эрх тэгш байдлын талаар гомдол, түүний шийдвэрлэлт” (Гомдол шийдвэрлэх дотоодын болон олон улсын эрх зүйн зохицуулалт, механизм), “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилт” зэрэг тодорхой сэдвүүдээр нийт 2000 гаруй хүнд 60 гаруй цагийн сургалтуудыг зохион байгуулсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийслэлийн болон 16 аймгийн төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудад “Жендэр ба хүний эрх” сэдвээр сургалт, 2019 он.</li> <li>• Хэнтий аймагт 2018-06-15, 16-ны өдрүүдэд, Сүхбаатар аймагт 2018-06-12, 13-ны өдрүүдэд, Дорнод аймагт 2018-06-8, 9-ны өдрүүдэд, Баруун, Төв, Говийн бүсийн аймгуудад 2018-9,10 дугаар саруудад тус тус төрийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн ажилтнуудыг “Жендэрийн сургагч багш”-аар бэлтгэх сургалтад Жендэрийн эрх тэгш байдлын талаар гомдол, түүний шийдвэрлэлт (Гомдол шийдвэрлэх дотоодын болон олон улсын эрх зүйн зохицуулалт, механизм) сэдвээр</li> <li>• ХНХЯ-ны харьяа Олон улсын хүүхдийн Найрамдал зуслангийн ажилтнуудад “Төрийн албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал” сэдвээр, 2019-03-01</li> <li>• Эрүү шүүлтийн эсрэг элчин сайд хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн сургагч багш бэлтгэх “Эрүү шүүлтээс ангид байх эрх” сэдэвт сургалтад Эрүү шүүлтийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нь сэдвээр</li> <li>• “2016 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 09 дүгээр сарын 24-ний өдрүүдэд баруун бүсийн 5 аймгийн, 2016 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс 10 дугаар сарын 07-ны өдрүүдэд төвийн бүсийн 6 аймгийг хамруулан Нээлттэй Нийгэм форумаас зохион байгуулсан Иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхижуулах 2 дахь шатны бүсчилсэн сургалтад сургагч багшаар ажиллаж, “Хууль сахиулах байгууллагын шинэчлэл ба Цагдаагийн албаны шинэчлэл”, “Цагдан хорих байранд мониторинг хийх нь” зэрэг сэдвээр</li> <li>• Говьсүмбэр аймгийн хуулийн байгууллагын ажилтнуудад “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрх” сэдвээр, 2015.06.09</li> <li>• Дорноговь аймгийн хуулийн байгууллагын ажилтнуудад “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрх” сэдвээр, 2015.06.04</li> <li>• Хөвсгөл аймгийн Цагаан нуур сум дахь болон Улаан уул сум дахь хилийн цэргийн застав, хилийн цэргийн 0257 дугаар ангийн алба хаагчдад “” сэдвээр 2015.05 сар</li> <li>• Хөвсгөл аймгийн хуулийн байгууллагын ажилтнуудад “Хүний эрхийн зөрчлийг эрх зүйн зөрчлөөс ялгах нь” сэдвээр 2015.05.22</li> <li>• Архангай аймгийн хуулийн байгууллагын ажилтнуудад “Хүний эрхийн зөрчлийг эрх</li> </ul>
--	--

		<p>зүйн зөрчлөөс ялгах нь” сэдвээр, 2015.05.19</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хорих 427 дугаар ангийн хорих ангийн удирдлага, алба хаагчдад дараах Хүний эрхийн үндсэн ойлголт, Хүний эрхэд суурилсан хандлага, Албадан хөдөлмөрийн асуудал, Жендерт суурилсан хүчирхийлэл ба ажлын байрны бэлгийн дарамт, Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь, Эрүү шүүлт ба хүний эрх зэрэг сэдвүүдээр, 2014.06.10</li> <li>• Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий газрын харьяа дараах ангиудад Албадан хөдөлмөрийн асуудал, Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь, Эрүү шүүлт ба хүний эрх сэдвүүдээр: /Хорих 421, 431 дүгээр ангиудад 2014.05.27, Хорих 419 дүгээр ангид 2014.06.25, Хорих 413, 433 дугаар ангиудад 2014.06.16, Хорих 417 дугаар ангид 2014.06.11, Хорих 409 дүгээр ангид 2014.05.28, Хорих 407, 441 дүгээр ангиудад 2014.05.06, Хорих 405, 429 дүгээр ангиудад 2014.06.25, Хорих 401, 411 дүгээр ангиудад 2014.05.26, Цагдан хорих 0461 дүгээр анги 2014.05.25, Хорих 437 дугаар анги/</li> <li>• Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн төрийн захиргааны алба хаагчдад “Хүний эрхийн зөрчил” сэдвээр, 2014.09.20-09.30</li> <li>• Завхан аймгийн Төрийн үйлчилгээний байгууллагын алба хаагчдад “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст хэрхэн гомдол гаргах, гаргасан гомдлын шийдвэрлэлт”, “Хөдөлмөрлөх эрхийн асуудал” сэдвээр, 2014.05</li> <li>• Завхан аймгийн Төрийн захиргааны байгууллагын алба хаагчдад “Хүний эрхийн зөрчлийг эрх зүйн зөрчлөөс ялгах нь”, “Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал” сэдвээр, 2014.04.24</li> <li>• Завхан аймгийн Хууль сахиулах байгууллагын /шүүгч, прокурор, цагдаагийн болон шүүхийн шийдвэр Гүйцэтгэх/ байгууллагын алба хаагчдад “Эрүү шүүлтээс ангид байх эрхийн асуудал” сэдвээр, 2014.04.24</li> <li>• ХАХНХЯ, Нийгмийн халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын газар, Хүүхдийн төлөө Үндэсний газар, Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвийн бодлогын асуудал хариуцсан ажилтнуудад “Хөдөлмөрийн харилцаан дахь хүний эрхийн зарчмууд” сэдвээр, 2014.01.22</li> <li>• Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Айфо байгууллага хамтран зохион байгуулсан “Сэтгэцийн өнөөгийн тулгамдсан асуудал” сэдэвт сургалтад “Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн эрхийн асуудал” сэдвээр, 2013.10.01</li> <li>• Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн эмч, өрхийн эмч нарт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенц, түүний хэрэгжилт” сэдвээр, 2013 он</li> <li>• Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яам, Сэргээн засалтын Үндэсний төвөөс хамтран зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн хэрэгжилт” сэдэвт Иргэний нийгмийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалтад “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилт” сэдвээр, 2012.05 сард тус тус сургалт зохион байгуулав.</li> </ul> <p><b>Жич:</b> Жишээ болгож батлагдсан Сургалтын хөтөлбөрийн хуулбарыг хавсаргав.</p>
--	--	---

**Хүний эрхийг хамгаалах чиглэлээр:**

**үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн хэлтсийн даргаар ажиллаж байна. Ажилласан хугацаа 9 жил 4 сар.

Комиссоос сүүлийн 5 жилийн байдлаар /2015-2020 оны эхний улирал/ нийт 10,195 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хууль зүйн зөвлөгөө, 609 хяналт шалгалт, 3,121 гомдол мэдээлэлд шалгах ажиллагаа явуулахад ажилтнуудыг өдөр тутмын мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллав. Мөн Комиссын гишүүний 171 шаардлага, Комиссын гишүүний 188 зөвлөмж, иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээлгэхээр шүүхэд 15 нэхэмжлэлийг гаргахад баримт бичгийн боловсруулалт, хууль зүйн үндэслэл хянаж, үр дүн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж, жил бүр ажлын гүйцэтгэлээ “А” буюу хангалттай дүнтэйгээр дүгнүүлсэн болно.

Хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилласан ажлуудын заримаас дурдвал:

1. Комиссоос хүний эрхийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх, иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтнуудын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг арилгуулах, таслан зогсоох зорилгоор асрамжийн газар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургууль, дотуур байр, хорих, цагдан хорих байр, эрүүлжүүлэх, саатуулах байр болон бусад холбогдох байгууллагуудад хяналт шалгалт явуулах, иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, төрийн байгууллагуудаас нийтээр мөрдөх хэм хэмжээ тогтоосон захиргааны актуудад дүн шинжилгээ хийх, сум орон нутгийн иргэдтэй уулзах зэрэг цогц арга хэмжээний хүрээнд “Хүний эрхийн нээлттэй өдөр”-ийг давхардсан тоогоор 21 аймаг, 246 суманд зохион байгуулахад идэвхтэй оролцож, тухайн арга хэмжээг мэргэжлийн түвшинд амжилттай зохион байгуулсан байна. *Жишээ болгож “Хүний эрхийн нээлттэй өдөр” арга хэмжээний нэг удирдамжийн хуулбарыг хавсаргав.*
2. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр 2018-2022 онд хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн хүрээнд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын хэсэг Өвөрхангай, Говь-Алтай, Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Өмнөговь, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Завхан, Архангай, Төв, Хөвсгөл, Булган зэрэг нийт 16 аймгийн Засаг даргын тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын газар, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв зэрэг нийт 160 байгууллагад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд 2019-4-өөс 10 дугаар сарыг хүртлэх хугацаанд хяналт шалгалт хийсэн. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэлийн Хоёрдугаар бүлэг, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр боловсруулсан илтгэлд тусгагдсан. Дэлгэрэнгүйг *Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх*

		<p><u>19 дэх илтгэл, Хоёрдугаар бүлэг. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт”, <a href="http://nhrcm.gov.mn/">http://nhrcm.gov.mn/</a></u></p> <p>3. Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээс гадна иргэний халдашгүй, чөлөөтэй байх эрх, хохирогчийн эрх, хамгаалал, хөдөлмөрлөх эрх, албадан хөдөлмөрийн асуудал, эрүү шүүлтээс ангид байх эрх болон жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг илүүтэй судалж, энэ чиглэлээр мэргэшин ажиллаж байна. <u>Холбогдох тушаалын хуулбарыг хавсаргав.</u></p> <p>4. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд зааснаар Комиссын гишүүн эрх нь зөрчигдсөн иргэнийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд гишүүдээс олгосон итгэмжлэлийн дагуу шүүх хуралдаанд оролцон ажиллаж байна. <u>Жишээ болгож Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр болон Хэнтий аймгийн Сүм дундын иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг тус тус хавсаргав.</u></p> <p><b>Ажлын байрны тодорхойлолт:</b> Комиссын гишүүд хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, Комиссын гишүүний гомдол мэдээлэл хүлээн авах, шалгах, шийдвэрлэх, шаардлага, зөвлөмж гаргах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, Комиссын гишүүний бүрэн эрхийг түүний нэрийн өмнөөс төлөөлөн хэрэгжүүлэх болон хуульд заасан бусад бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.</p> <p>Комиссын гишүүд хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, Комиссын гишүүний гомдол мэдээлэл хүлээн авах, шалгах, шийдвэрлэх, шаардлага, зөвлөмж гаргах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, Комиссын гишүүний бүрэн эрхийг түүний нэрийн өмнөөс төлөөлөн хэрэгжүүлэх болон хуульд заасан бусад бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллаж байна.</p>
